



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/М

Булган сум

Ажил эрчимжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV хуралдааны XIV/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2023 оны 04 дүгээр сарын 30-ны дотор зарлах зохион байгуулалтын арга хэмжээ авч, ажил эрчимжүүлэхийг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т даалгасугай.

2. Худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд тусгасан төсөл арга хэмжээний зураг төсвийг 2023 оны 04 дүгээр сарын 01-ны дотор бүрдүүлж, Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т, Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т тус тус үүрэг болгосугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний зохион байгуулалтад хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахын аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням)-т чиглэл болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

